



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны 11 сарын 08 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль<sup>[4]</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО,  
ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл		Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд		2,514,881.8
	1.1	Ажил даатгуулагчаас олгогч, төлөх шимтгэл	1,145,715.8
	1.2	Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	353,036.7
	1.3	Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	966,297.8
	1.4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	49,831.5
Нийт орлого			2,514,881.8

/Энэ зүйлийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөрийг төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
-----	-----------------------------	------------------------

1	Эрүүл мэндийн сайд	77,600.0
---	--------------------	----------

5 дугаар зүйл.2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсвийг зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл		Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд		2,293,894.9
	1.1	Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	985,316.6
	1.2	Төрөөс хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,119,081.9
	1.3	Эмийн санд олгох	171,485.3
	1.4	Үйл ажиллагааны урсгал зардал	18,011.0
	Нийт зарлага		2,293,894.9

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН